

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

**АЗИЙН БУДДИСТУУДЫН ЭНХ ТАЙВНЫ
ХӨДӨЛГӨӨНИЙ АСУУДАЛД****Т. Содномдаргиа**

Философийн ухааны дэд эрдэмтэн.

Өнөө үед энх тайвны төлөө тэмцэх явдал бүх нийтийн шинжтэй болж, түүнд дэлхийн улс төрийн намууд, засгийн газар, үйлдвэрчний эвлэл, эмэгтэйчүүд, залуучууд, урлаг, соёлын болон шашны байгууллага, хөдөлгөөнүүд идэвхтэй оролцож байна. Тухайлбал энхийн төлөө тэмцэлд Азийн буддистуудын хүч, эв нэгдлийг нягтруулан бэхжүүлэхэд бүддийн шашны олон улсын байгууллага болох Азийн буддистуудын энх тайвны бага хурлын (АБЭТБХ) үйл ажиллагаа нэлээд чухал үүрэг гүйцэтгэж байна.¹ АБЭТБХ бол энх тайван, хүнлэг, шударга ёсыг сахин хамгаалахын төлөө Азийн дэвшилт буддист олон нийтийн хүсэл эрмэлзлэлийг илэрхийлсэн энхийг эрхэмлэгч хөдөлгөөн юм.

АБЭТБХ байгуулагдсан цагаасаа эхлэн Азийн энх тайван, аюулгүй байдал, ялангуяа Энэтхэг—Хятадын хойгт болж байсан түрэмгий дайныг зогсоох, бусад бүс нутаг дахь түгшүүртэй, маргаантай буй асуудлыг энх тайван замаар зохицуулан шийдэхэд бүхий л үйл ажиллагаагаа чиглүүлж иржээ. Энэ нь түүний үйл ажиллагааны гол хэлбэр болох АБЭТБХ-ын ээлжит Ерөнхий бага хурлуудын хэлэлцэх асуудлын гол сэдэв болж түүний үндсэн баримт бичгүүдэд тусгагдсан байна.

Өнгөрсөн хугацаанд АБЭТБХ ээлжит Ерөнхий бага хурлаа 6 удаа хийгээд байна. Түүний I Ерөнхий бага хурал 1970 онд Улаанбаатар хотноо болж «Энх тайвны төлөө Азийн Бурханы шашинтны хамтын ажиллагааг өрнүүлэе», «Вьетнам болон Азийн үндэсний тусгаар тогтнол, энх тайван, уламжлалт соёлын өвийг хамгаалъя» гэсэн хоёр асуудал авч хэлэлцэн, асуудал тус бүрээр тусгай тогтоол, Азийн буддистуудад хандсан уриалга гаргажээ.

АБЭТБХ II Ерөнхий бага хурал 1972 онд Шриланкийн Канди хотноо болж «Энх тайван бол нийгмийн дэвшлийн чухал нөхцөл мөн» гэсэн асуудал авч хэлэлцээд Азийн буддистуудын энх тайвны хөдөлгөөний үндсэн асуудлаар «Ерөнхий тогтоол», «Энэтхэг—Хятадын хойгт энх тайвныг тогтоох асуудлаар тусгай тогтоол», «Бүх буддистуудад хан-

*1970 онд Улаанбаатар хотноо Монгол, Энэтхэг, Балба, Шриланка, Малайз, Сингапур, Япон, Зөвлөлт, Вьетнам зэрэг улсын Бүддийн шашны төлөөлөгчдийн уулзалт болж Азийн буддистуудын энх тайвны бага хурлыг анх үндэслэн байгуулсан юм. Одоо Балба, Бангладеш, Вьетнам Шриланка, Энэтхэг, Тайланд, Япон зэрэг Азийн 10 гаруй оронд Азийн буддистуудын энх тайвны бага хурлын үндэсний 15 төв ажиллаж байна. Азийн буддистуудын энх тайвны бага хурлын удирдах төв нь БНМАУ-ын нийслэл Улаанбаатарт байрлаж байна.

даж гаргасан энх тайвны уриалга» зэрэг баримт бичгийг батлан гаргажээ.

АБЭТБХ-ын III Ерөнхий бага хурал 1974 онд Энэтхэгийн Шинэ Дели хотноо болж тухайн цаг үеийн байдалд нарийн дүн шинжилгээ хийж тус хөдөлгөөний өмнө тулгарч буй зорилтыг тодорхойлон «Шинэ Делийн тунхаглал», «Вьетнам, Лаос, Кампучийн талаар тусгай тогтоол» батлан гаргасан юм.

АБЭТБХ-ын IV Ерөнхий бага хурал 1976 онд Японы нийслэл Токиод болж Бүддийн нигүүлсэнгүй үзэл сургаалын дагуу бүх нийтийн энх амгалан тогтоох асуудлыг хэлэлцэж «Токиогийн уриалга», «Ерөнхий тогтоол», «Тусгай тогтоол»-ыг батлан гаргасан болно.

Азийн Буддистуудын Энх Тайвны Бага Хурлын V Ерөнхий бага хурал 1971 онд Улаанбаатар хотноо «Буддистууд энх тайван, эв нэгдэл, шударга ёсны төлөө» уриан дор болж Ази болон даян дэлхийн буддистуудад хандсан «Улаанбаатарын уриалга», «Азийн Буддистуудын Энх тайвны бага хурлын V Ерөнхий Бага хурлын Ерөнхий тогтоол» зэрэг баримт бичгийг гаргасан байна.

1982 онд Улаанбаатар хотноо АБЭТБХ-ын VI Ерөнхий бага хурал «Буддын энх амгалангийн үзэл санааг хэрэгжүүлэе» уриан дор болж, өнгөрсөн хугацаанд тус хөдөлгөөний явуулсан үйл ажиллагаанд дүгнэлт өгч энхийг эрхэмлэгч буддистуудын өмнө тавигдаж байгаа ээлжит зорилтыг тодорхойлов. Тус бага хурлаас «Улаанбаатарын уриалга», «Азийн буддистуудын энх тайвны бага хурлын Ерөнхий тогтоол», «Ливаны эсрэг Израилийн түрэмгийллийн талаархи VI Ерөнхий бага хурлын мэдэгдэл» зэрэг баримт бичгийг батлан гаргажээ.

АБЭТБХ-ын ээлжит ерөнхий бага хурлуудын дотроос 1974 онд Шинэ Дели хотноо хуран чуулсан III Ерөнхий бага хурал тус хөдөлгөөний хөгжилд онцгой, түүхэн ач холбогдол бүхий арга хэмжээ болсон ажээ. III Ерөнхий бага хурлаас гаргасан «Шинэ Делийн тунхаглал» баримт бичигт уг хөдөлгөөний үүрэг зорилтыг дэвшүүлсэн нь цаашид, энхийн төлөө тэмцэлд буддистуудын эгнээг өргөтгөх, тэдний үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чухал алхам болжээ. «Шинэ Делийн тунхаглалын» заалтууд нь Азийн буддистуудын энх тайвны хөдөлгөөний мөрийн хөтөлбөр болон мөрдөгдөж иржээ.

Азийн буддистуудын энх тайвны бага хурлын ээлжит ерөнхий бага хурлууд, түүний шийдвэрийг хэрэгжүүлэх практик үйл ажиллагаанаас үзэхүл тус хөдөлгөөн дараахь чиглэлүүдийг өөрийн үйл ажиллагааны зарчмын эрхэмлэх зүйлээ болгон ажиллаж байна.

Нэгдүгээрт. Азийн Бурханы шашинтан нар хамтарч Ази ба дэлхий дахинд энх амгаланг өрнүүлэхийн төлөө шашинтны уялдаа зохицолдоо бүхий ажиллагааг өрнүүлэх явдлыг Азийн Буддистуудын Энх тайвны бага хурал үүсэн байгуулагдсанаасаа аваад гол эрхэмлэх зүйлээ болгож тус бүр нутгийн буддистуудыг энхийн төлөө ариун үйлст уриалан дуудаж иржээ. Азийн Буддистуудын Энх тайвны бага хурлын I Ерөнхий бага хурал тавьсан илтгэлдээ Азийн Буддистуудын Энх тайвны бага хурлын ерөнхийлөгч, талийгаач С. Гомбожав «Олон улсаараа айх аюулгүй, амар жимэр, аж төрөхийн төлөө хичээнгүйлэх нь манай шашны чин зорилго билээ. Иймээс бид өөр өөрийн орны ард түмэн, сүсэгтэн олныг энх амгалангийн төлөө идэвхтэй тэмцэлд нэгтгэж, засгийн газраа тууштай энх тайванч бодлого баримталдаг болгохыг шашин нэгтэй Азийн орны сүм хийдийнхэн, лам нар сүсэгтэн олондоо

чин сэтгэлийн угаас хүсэн уриалж байна»² гэж тэмдэглэжээ. Энхийн төлөө тэмцэлд буддистуудыг үйл ажиллагааг өргөжүүлэх, түүнийг идэвхжүүлэх явдлыг Азийн Буддистуудын Энх тайвны бага хурлын удаа дараагийн Бага хурлуудын материалд тусгасан болно.

Хоёрдугаарт. Азийн Буддистуудын Энх Тайвны бага хурлын улс төрийн байр суурь, үйл ажиллагаанд буддистуудын энх амгалан, шударга ёс, нигүүлсэнгүй үзэл санааг түгээн дэлгэрүүлж хэрэгжүүлэхийг мөрдлөг болгодог юм. Уг асуудлыг тусгайлан эрхэлсэн «Панчашилагийн үндсийг судлах, сурталчлах комисс» Азийн Буддистуудын Энх Тайвны бага хуралд байгуулагдан ажиллаж байна.

Гуравдугаарт. Цөмийн болоод үй олноор нь хөнөөх бусад зэвсгийг үйлдвэрлэх, турших, хадгалах, хэрэглэх явдлыг бүрмөсөн хориглохыг зорьж зэвсэглэлийг бүх нийтээр бүрэн хураахын төлөө тэмцлийг Азийн Буддистуудын Энх Тайвны Бага хурал шаргуу хийж байгаа болно. Азийн Буддистуудын Энх Тайвны Бага Хурал нь засгийн газрын бус байгууллагуудын зэвсэг хураах хорооны гишүүн бөгөөд түүний удаа дараагийн хурал, арга хэмжээнд оролцож ирэв.

Дөрөвдүгээрт. Өлсгөлөн гуйланчлал, харанхуй бүдүүлэг байдал болон нийгмийн байдлаар ялгаварлах, шашныг үл тэвчин гадуурхах, мөрдөн хавчих зэргийг арилгах замаар хүний эрхийг хүндэтгэн хамгаалах явдлыг Азийн Буддистуудын Энх Тайвны бага хурал өөрийн үзэл, үйл ажиллагааны нэг чухал чиглэлээ болгон үздэг болно.

Дэлхийн энхийг эрхэмлэгчдийн тэмдэглэн өнгөрүүлдэг энх тайвны өдөр долоо хоног сарын тохиолдуулан бага хурал зарим арга хэмжээг тухай бүрд нь Азийн Буддистуудын Энх Тайвны Бага Хурлын Удирдах Төв болон үндэсний төвүүд зохион явуулдаг болжээ. Тэрчлэн эрх чөлөө, тусгаар тогтнол, шударга ёс, шашин шүтлэгийнхээ төлөө шударгаар тэмцэж буй тухайн улс түмний тэмцлийг дэмжиж, тэдэнтэй эв санаагаа нэгтгэх зорилгын үүднээс Азийн Буддистуудын Энх Тайвны Бага Хурал мэдэгдлүүд гаргаж өөрийн байр сууриа илэрхийлж байдаг.

Тавдугаарт. Энхийн төлөө ажиллаж байгаа шашны ба шашны бус энх тайван, эв нэгдлийн төлөө бусад хөдөлгөөнтэй, хамтран ажиллахыг практик үйл ажиллагааны гол нэг зорилгоо болгодог юм.

Одоо Азийн Буддистуудын Энх Тайвны Бага Хурал Дэлхийн энх тайвны Зөвлөл, Христос шашинтны энх тайвны бага хурал (ХШЭТБХ) зэрэг шашны ба энх тайвны олон улсын дэвшилтэт ардчилсан 10 гаруй байгууллагатай нягт хамтран ажиллаж байна.

Энхийн төлөө Азийн буддистуудын үйл ажиллагаа сүүлийн үед улам бүр өргөжин идэвхжиж байна. Үүнийг 1982 онд Улаанбаатар хотноо болсон VI Ерөнхий бага хурал дэлхий дахины өнөөгийн байдалд дүн шинжилгээ өгч тус хөдөлгөөний цаашдын тулгамдмал зорилт, түүнд буддистуудын оруулах үйл ажиллагааны чухал чухал асуудлыг авч хэлэлцсэн байдлаас бид тодорхой харж байна.

Азийн буддистуудын энх тайвны бага хурлын VI Ерөнхий бага хурлын «Ерөнхий тогтоол»-д дэлхийн улс түмний харилцаан дахь өнөөгийн уур амьсгалыг тодорхойлохдоо: «80-аад оны эхэн үе бол олон улсын байдал эрс хурцдаж дэлхий дахинаа мөргөлдөөн хүчтэй болж, тив дэлхийг хамарсан цөмийн дайны сүйрэл үүсэх аюул нэмэгдсээр байна. Империалист түрэмгий харгис хүчин энх тайвны эрх ашигт

²ABCP., Bulletin, No 1, Ulan-Bator, 1971, P. 6.

дайсагнасан, харш бодлого явуулж байгаагийн улмаас цөмийн дайны аюул ийнхүү бий боллоо»³ гэжээ.

Орчин үед улс түмний харилцаанд төвөгтэй, ноцтой хурцадмал асуудлууд гарсаар байна. Америкийн империалист харгис хүчин, жанжлах үзэлтнүүд, харгис бусад хүчнийхэн эвсэн сүлбэлдэж олон улсын намжмал байдлын үйл явцыг зэвсэглэлээр хөөцөлдөн бусниулж цэрэг улс төрийн сөргөлдөөнийг дэвэргэх, түүнийг шатлан өргөжүүлэх бодлогыг илэрхий явуулах болов. Тэрчлэн олон улсын харилцаанд хүчээр түрээ барих, айлган сүрдүүлэх, бусдын дотоод хэрэгт хөндлөнгөөс ичгүүр сонжуургүй оролцох түрэмгий бодлогоо тэд даамжруулж байна. АНУ цэргийн баазуудаа Ази, Номхон далайн сав газруудад нэмэн байрлуулсаар байгаа бөгөөд тэднийхээ хүчин чадлыг шинэчлэн «сайжруулж» байна.

Энэхүү нөхцөл байдалд тус ерөнхий бага хурал тодорхой дүгнэлт хийж бүддистуудын өмнө зогсож буй дараахь зорилтуудыг дэвшүүлсэн болно. Үүнд:

--Улс түмний амар амгалан, аз жаргалтай амьдрах ариун эрхийг хамгаалахын тулд өөр өөрийн улс орон, бүс нутагт дайны аюул, зэвсэглэлээр хөөцөлдөхийн эсрэг, зэвсэг хураахын төлөө хөдөлгөөнийг газар сайгүй өрнүүлэх;

--Энх тайван, аюулгүй байдлыг хангах, харилцан ойлголцох явдлыг бэхжүүлэх, сайн хөршийн харилцааг хөгжүүлэх, Ази болон дэлхий дахины улс орон, ард түмний хооронд хүч хэрэглэхийг хориглоход чиглэсэн энхийг эрхэмлэгч улсуудын санаачилга, саналыг дэмжихэд өөр өөрсдийн орны өргөн олон нийтийн санаа бодлыг дайчлахад идэвхтэй тус дөхөм үзүүлэх;

--Цөмийн зэвсгийг түрүүлж хэрэглэхгүй байх тухай ЗСБНХУ-ын үүрэг амлалтанд халуун баяр хүргэж ийм хатуу үүрэг амлалтыг цөмийн зэвсэгтэй бусад гүрнээр авахуулахын төлөө идэвхтэй тэмцэх

--Империалист харгис бүлгийнхэн болон тэднийг дэмжигч Ази дахь хүчний өнгөлзлөгийн эсрэг тэмцэж, улс түмний бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг эвдэн бусниулах, хөндлөнгөөс оролцох бодлогыг хэрэгжүүлэх зэвсэг болж байгаа цөмийн бааз, эвслийг устган, түүнийг шинээр байгуулахгүй байлгах;

--Цөмийн дайны аюул занал өсөн нэмэгдэж, зэвсгээр хөөцөлдөх түгшүүртэй байдал хурцдахын эх үүсвэрийн талаар болон намжмал байдлыг сахин хамгаалж, бэхжүүлэхийн чухлыг өргөн тайлбарлах;

--Үндэсний болон олон улсын байгууллага, дайны эсрэг шашны болон шашны бус өргөн олны хөдөлгөөний шугамаар энх тайвныг сахин хамгаалах, зэвсэг хураахын төлөө, зэвсгээр хөөцөлдөх явдлын эсрэг явуулж байгаа энхийг эрхэмлэгч тэмцэл, кампанит ажилд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх;

--Үндэсний бүс нутгийн болон олон улсын хэмжээнд энх тайвны аян, нийтийн жагсаал, цуглаан, хурал, семинар, симпозиум болон гарын үсэг цуглуулах, илгээлт өргөх зэрэг энх тайвныг тэтгэгч олон нийтийн арга хэмжээг санаачлагч, идэвхтэй оролцогч нь байх; Мөн АБЭТБХ-ын Дүрмийн эрмэлзэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, Панчшилагийн зарчмыг түгээн дэлгэрүүлэх, залуучууд, эмэгтэйчүүдийг энх тайвны үзэл санаагаар хүмүүжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэхийг бүх бүддистуудад хандаж VI Ерөнхий бага хурлаас гаргасан «Улаанбаатарын уриалгад» тодорхойлсон байна.⁴

³АВСР., Bulletin, No 4, Ulan-Bator, 1982, P. 6.

⁴АВСР., Bulletin, No 4, Ulan-Bator, 1982, P. 3—4.

Эдгээр дэвшүүлсэн зорилтоос үзэхүл энхийн төлөө азийн бүддистуудын энх тайвны бага хурал энэрэнгүй нигүүлсэн үзлийнхээ үүднээс юуны өмнө энхийн төлөө тэмцэгч бүх шашинтай нягт хамтран ажиллах, харилцан ойлголцсоны үндсэн дээр цэрэг дайны аюул заналыг сэргэмжлэн зайлуулж намжмал байдлыг улам далайцтай эрч хүчтэй болгохын төлөө тэмцэлд энхийг эрхэмлэгч бусад бүх хүчинтэй хамтран шаргуу тэмцэхийг уриалжээ.

Энэ бол чухал асуудал юм. Нэгэнт бий болсон намжмал байдлыг тууштай хэрэгжүүлэх явдал орчин үеийн олон улсын харилцааны амин чухал эрх ашиг болж байна. Энэ нь тухайлбал хүн ам шигүү оршин суудаг Ази тивд энх амгалан аюулгүй бэхжүүлэх угтвар таатай нөхцөлийг бий болгох юм.

Ази тивийн улс түмний харилцааны өнөө үеийн онцлог шинж нь АНУ тэргүүтэй империализмын харгис хүчний түрэмгийлэл, их гүрний жанжлагч үзэлтнүүдийн түрэмгийлэх санаархалыг хамтын хүчээр няцааж, тус бүс нутгийн ард түмэн энх амгалан аж төрөхийн төлөө эрх тэгш, найрсаг хамтын ажиллагааг өрнүүлэх, үндэсний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа хамгаалахын төлөө тэмцэх шийдвэр төгс байгаагаар тодорхойлогдож байна. Хөрш улсуудын бүрэн эрх, газар нутгийн халдашгүй дархан байдал руу өнгөлзөх, цэрэг—улс төр, эдийн засгийн шахалт даралт үзүүлэх, тэдний дотоод хэрэгт хөндлөнгөөс орох, элдвээр гүтгэх, хагалан бутаргахад чиглэсэн АНУ-ын балмад явуулгыг тус бага хурал эрс шүүмжлэн хэлэлцэв. Тухайлбал Ливаны болон палестины ард түмний эсрэг үргэлжлүүлсээр байгаа Израилийн түрэмгийлэлд бүддистууд сэтгэл гүн түгшиж байгаагаа илэрхийлэн эрс шүүмжилжээ.

Ливанд Израилийн үйлдэж байгаа түрэмгийлэлтэй холбогдуулан тус VI Ерөнхий бага хурлаас гаргасан мэдэгдэлд: Ливаны нутаг дэвсгэр дээр Израилийн сионистуудын үйлдэж байгаа бузар булай ялт хэргийг шударга хүн бүр тэвчин өнгөрч чадахгүй. Дайны гал түймэрт ямар ч гэм зэмгүй энгийн номхон оршин суугчид, эмэгтэйчүүд, өвгөд хөгшид, хүүхэд багачууд хэлмэгдэж байна. Израилийн түрэмгийлэгчид өөрийн түнш АНУ болон тэднийг ивээн тэтгэгчдийн их хэмжээгээр нийлүүлж байгаа үй олноор хөнөөгч хамгийн хүнлэг биш зэвсгийг хэрэглэж байна гэдгийг тэмдэглэж цааш нь Ливанд Израилийн одоо үйлдэж байгаа түрэмгийлэлтэй холбогдуулан НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс гаргасан шийдвэрүүдийг бид бүрэн дэмжиж, тэдгээрийг нэн даруй хэрэгжүүлэхийг эрс шийдвэртэй шаардаж байна. Хэрэв дэлхийн хамтын нийгэмлэгийн шаардлагыг түрэмгийлэлд үл тоомсорлосон хэвээр байвал Израилийн даварсан булаан эзлэгчдэд НҮБ хатуу хориг тавих ёстой. Шударга ёс ялж, палестины араб түмний аж төрөх, эрх чөлөөтэй, тусгаар тогтнон хөгжих эрхийг хангах ёстой⁵ гэж мэдэгдсэн байна.

Арабын ард түмний эзлэгдсэн газар нутгаас Израилийн булаан эзлэгчдийг зайлуулах, Палестины ард түмэнд эрх чөлөө, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах, тэд өөрийн төр улсаа байгуулахгүйгээр Ойрхи Дорнодод шударга ёс, бат бэх энх тайван, аюулгүй байдал тогтоож чадахгүй юм.

Энэ бүхнээс үзэхүл Азийн дэвшилт бүддистууд энх тайвны төлөө шударга тэмцэлд татагдаж орчин үеийн нийгмийн дэвшилд зохицон хандаж байгаа нь тодорхой байна. Энэ нь энх тайвны дайснууд идэвх-

⁵ABCP., Bulletin, No 4, Ulan-Bator, 1982, P. 14

жиг, олон улсын байдал нэн хурцадмал болж буй өнөө үед багагүй ач холбогдолтой бөгөөд энхийг-эрхэмлэгч шашны ба шашны бус хүчнүүдтэй үйл ажиллагаа, харилцаа холбоогоо өргөжүүлэн зохицуулах энх тайвны хөдөлгөөнийг Азид улам хүчтэй өрнүүлэхэд тус дөхөм үзүүлэх юм.

АЗИАТСКИЕ БУДДИСТЫ В БОРБЕ ЗА МИР.

(Резюме)

Важную роль в борьбе за мир играет международная организация буддистов Азии— Азиатская буддистская конференция за мир (АБКМ), основанная с 1970 году в Улан-Баторе и объединяющая буддистов из 10 стран.

Согласно уставу, АБКМ представляет собой развернувшееся движение буддистов Азии, выражающее искренние чаяния учеников Будды за утверждение мира и справедливости.

Со дня оснозапия, на всех своих прошедших сессиях, АБКМ, обсуждала актуальные вопросы движения за мир, уделяя особое внимание борьбе против возникновения военной опасности, за укрепление сотрудничества и взаимопонимания между странами азиатского континента. При АБКМ тачже постоянно действуют. «Комиссия по изучению и пропаганде основ 5-ти мирных принципов—«Панчашила» и «Комиссия по разоружению».

Одной из главных практических задач АБКМ является расширение и активизация сотрудничества с другими, как религиозными, так и общественными организациями, выступающими за мир и разоружение, против гонки вооружений. В обязанности штаб—квартиры АБКМ и её национальных центров входит проведение крупных мероприятий, служащих распространению идей мира и ознакомлению всех слоев общественности с целями и задачами Конференции.

Антивоенная деятельность АБКМ способствует распространению в Азии идей мира и дружбы, утверждению принципов мирного сосуществования государств с различным общественным строем.

АБКМ полностью поддерживает миролюбивую политику прогрессивных сил, в частности Советского Союза, видя в них реальную альтернативу опасному курсу империализма на взвинчивание гонки вооружений и нагнетание международной напряженности, на наращивание своего военного присутствия в различных регионах мира.

Азиатское буддистское духовенство сознает свою ответственность за защиту всего живого и присоединяется к борьбе народов за мир и безопасность на земле. Кроме того, оно уделяет внимание укреплению единства движения миролюбивых буддистов, расширению его географических рамок и вовлечению в него новых сил.

На данном этапе важное значение приобретает ззаимопонимание между религиозными и общественными организациями. В связи с этим АБКМ видит свою цель в постоянном расширении контактов с неправительственными международными организациями, нацеливая свою деятельность на решение актуальных проблем современности.